

ТӨВ АЙМГИЙН 2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2023 оны 02 сарын 05-ны өдөр

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2023 оны 01 дүгээр сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн ИТХ, Ажлын албанаас 2023 оны 01 сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Аймгийн ИТХ-ын Зөвлөл:

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн 2023 оны 01 дүгээр Хуралдаан 2023 оны 01-р сарын 24-ний өдөр хуралдаж 15 асуудал хэлэлцлээ.

1.Аймгийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх тухай

2.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц

3.Хөгжлийн Түүхээ-Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явц зэрэг бодлогын 3 баримт бичгийн асуудлуудыг хэлэлцэн Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжил, Нутгийн удирдлага, цахим хөгжил, Нийгмийн бодлого, хүний хөгжил, Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжил, Хот суурин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн хөгжил, Хүний эрх, өргөдөл гомдлын хороодод тус тус шилжүүллээ.

4.Олон нийтийн цагдаагийн ажилтны тоо тогтоох тухай

5.Аймгийн 2022 оны гадаад харилцаа, хамтын ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын 14 дүгээр Хуралдаанаар аймгийн 2023 оны гадаад харилцаа, хамтын ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзэв.

6.Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцтай танилцан Хурлын Нутгийн удирдлага, Цахим хөгжлийн хороонд шилжүүллээ.

7.Газрын дуудлага худалдааны орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, зарцуулах, тайлагнах журам батлах тухай аймгийн ИТХ-ын 2022 оны 05-р сарын 19-ний өдрийн 03 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай

8.Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хаягдлыг булшлах зардлын нэгж тариф шинэчлэн батлах тухай асуудлуудыг хэлэлцээд Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороонд шилжүүллээ.

9.Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн байгуулах тухай

10.Аймгийн ГХУСАЗСЗөвлөлийн гишүүдийг шинэчлэн байгуулах тухай

11.Аймгийн ИТХ-ын Хуралдаанаар 2023 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө батлах тухай асуудлуудыг хэлэлцээд Хурлын хуралдаанд шилжүүллээ.

12.Хуралдааны тов тогтоож, хэлэлцэх асуудлын дараалал тогтоох асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын ээлжит 14-р хуралдааныг 2022 оны 02 сарын 01-ний өдөр хуралдахаар товлон хуралдаанаар нийт 12 асуудал хэлэлцүүлэхээр тогтоож аймгийн ИТХ-ын даргын захирамжаар шийдвэрлэв.

13.Аймгийн ИТХ-ын 12 дугаар Хуралдаанаар хэлэлцэгдсэн Сэргэлэн, Зуунмод сумын хилийн цэсийн асуудал өргөн мэдүүлэгдээгүй хойшлогдсонтой холбогдуулан холбогдох мэдээллийг сонсож тус асуудлыг эрчимжүүлэхийг үүрэг болгов.

14.Хөрөнгө шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцээд Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

15. Мөн аймгийн ИТХ-ын Зөвлөлийн 1 дүгээр Хуралдаанаар 2023 онд худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн ажлын тухай мэдээллийг сонсч, ажил эрчимжүүлэх талаар чиглэл хүргүүлэхээр чиглэл өгөв.

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар нийт 15 асуудал хэлэлцэж Хурлын хороодод 12 асуудал шилжүүлж, 2 асуудлаар холбогдох чиглэл өгөв.

Аймгийн ИТХ-ын 14 дүгээр хуралдааны тов тогтсонтой холбогдуулан 01-р сарын 27-нд Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо, Хүний эрх, өргөдөл гомдлын хороо, 01-р сарын 30-нд Хурлын Нутгийн удирдлага, цахим хөгжил, Нийгмийн бодлого, хүний хөгжлийн хороо, Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороо, Хот суурин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн хөгжлийн хороод тус тус хуралдаж, холбогдох санал дүгнэлтээ гаргалаа.

Аймгийн ИТХ-ын Ажлын албаны хүрээнд:

2023 оны 01-р сарын 9-нд ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан заавар, маягтын дагуу аймгийн ИТХ-ын Ажлын алба 2023 оны байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө баталлаа.

Аймгийн ИТХ-ын Ажлын алба 2023 онд иргэдийн оролцоог хангах, олон нийтийн үүсгэл санаачлагыг дэмжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх, иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, төлөөлөх, эрх бүхий байгууллагад хуулиар харьяалуулсанаас бусад нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг бие даан шийдвэрлэх, төрийн бодлого шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ хангуулах, хяналт тавих, хурлын байгууллагын зохион байгуулалт, өөрийн дэргэдэх байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэн удирдах, орон нутгийн байгалийн баялаг, газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах, орон нутгийн төсөв, санхүү, өмчийн бодлого чиглэлийг тодорхойлж, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх, Хурлын Ажлын албыг бэхжүүлэх, хүний нөөцийг чадваржуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах зэрэг зорилт арга хэмжээнүүдийг тусган ажиллахаар төлөвлөж, аймгийн ИТХ-ын 14 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэв.

Монгол Улсад Шинэ Үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ой, Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулав. Үүнд:

-27 сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт болон байгууллагуудын удирдлагуудад 2023 оны 05 тоот албан бичгээр Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тус өдрөөр төрийн албан хаагчид үндэсний хувцасаа өмсөх, монгол өв уламжлал, зан заншлыг сурталчилсан тэмүүэн, уралдаан зохион байгуулах ажлуудыг хэрэгжүүлэн хийсэн ажлын тайлан мэдээг баримтжуулан ирүүлэх чиглэл хүргүүлэв. Энэ ажлын хүрээнд 11 байгууллага, 18 сум тодорхой ажил зохион байгуулав.

-Мөн аймгийн ИТХ болон Засаг даргаас Төв аймгаас сонгогдон Үндсэн хуулийг хэлэлцэн батлах үйл хэрэгт ард иргэдийнхээ төлөөлөл болон хувь нэмрээ оруулсан ахмад депутатууддаа аймгийн удирдлагууд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгууллаа.

-Аймгийн ИТХ-ын Ажлын албанаас “Монгол Улсын Үндсэн Хууль” сэдвээр 6 цуврал видео контент бэлтгэн нэвтрүүлж, Үндсэн хуулийг хэлэлцэн батласан депутатуудаас дурсамж яриа авч, видео мэдээлэл болон аймгийн ИТХ-ын даргын мэндчилгээг постер хэлбэрээр бэлтгэн нийтэд мэдээллээ.

-Үндсэн хуулийн өдөр аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсээс санаачлан нийт албан хаагчиддаа Монгол Улсын үндсэн хуулиас сурталчлан таниулах ажил зохион байгууллаа. Мөн энэ өдөр үндэсний дээл хувцас өмсөж, өв соёлоо хүндэтгэлээ.

-“Иргэдийн шударга шүүх” төрийн бус байгууллагаас 21 аймагт “Үндсэн хуулийн дугуйлан төсөл” хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Иргэдийн шударга шүүх” ТББ-ын тэргүүн Х.Бат-Ялалт сургалт зохион байгуулж, төрийн албан хаагчид хамрагдав.

Бусад ажлын хүрээнд:

-Аймгийн ИТХ-ын Ажлын албаны Хууль эрх зүй, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс болон Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсээс Төв аймгийн төрийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан авлигын эсрэг хууль тогтоомж, 2022 оны бүрдүүлэлтийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх зорилгоор 01-р сарын 23-нд цахим сургалт зохион байгуулав. Сургалтад аймгийн төвийн төрийн байгууллагууд болон 27 сумдын ИТХ, ЗДТГ-ын эрх бүхий бүхий албан тушаалтнууд хамрагдаж 2022 оны ХАСХОМ шинэчлэн мэдүүлэх тухай, цахим системд бүртгүүлэхэд анхаарах асуудал, Авлигын гэмт хэрэг, хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Албан тушаалын гэмт хэрэг, аймгийн нутаг дэвсгэрт 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын танилцуулга зэрэг зөвлөгөө мэдээллүүдийг нэгтгэн өглөө.

-Жендерийн Үндэсний хорооноос аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид, Нарийн бичгийн даргын жилийн мэдээг Үндэсний статистикийн хорооноос 2022.06.16-нд баталсан маягт, зааврын дагуу <https://sudalгаа.1212.mn/> цахим программд бүртгүүлэх чиглэл ирүүлсний дагуу аймгийн ИТХ-ын 41, 27 сумдын нийт 541 Төлөөлөгчийн бүртгэлийн мэдээг нэгтгэн цахим программд бүртгүүлсэн. Төв аймгийн 27 сумдын нийт Төлөөлөгчдийн 61 хувь нь эрэгтэй, 39 хувь нь эмэгтэй Төлөөлөгчид байгаа бөгөөд насны бүлгээр авч үзэхэд 45-55 насны Төлөөлөгчид хамгийн их буюу нийт Төлөөлөгчдийн 31.8 хувийг эзэлж байна.

Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хүйсийн тэнцвэрт байдлын тайлан, Жендерийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлогын хэрэгжилтийн тайланг аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч нарын хүйсийн тэнцвэрт байдлын мэдээг аймгийн ЗДТГ, сумын ИТХ-с авч нэгтгэн цахим программд оруулж, Жендерийн Үндэсний хороонд нэгтгэн хүргүүлэв.

-Сонгуулийн Ерөнхий хорооны 2023 оны 01-р сарын 02-ны өдрийн 1/02 тоот албан бичгийн дагуу “Аймаг, нийслэл сум, дүүргийн ИТХ-ын Сонгуулийн тухай хууль”-ийн 9-р зүйлийн 9.8-д “Орон нутгийн Хурлын нөхөн сонгуулийг тухайн аймаг, сум, нийслэл дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тухайн нөхцөл байдал үүссэнээс хойш 60 хоногт багтаан товлон зарлана” гэж зааснаар Хурлын Төлөөлөгчийн нөхөн сонгуулийг товлон зарлах тухай тогтоолыг ирүүлэх тухай албан бичгийг аймгийн Бүрэн, Өндөрширээт, Заамар сумдын ИТХ-д хүргүүлэв.

-2023 оны 1 дүгээр сард аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 38 албан бичиг ирснийг бүртгэн авч хариу хүргүүлэх шаардлагатай 6 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн ба Аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд иргэдээс 4 өргөдөл ирснээс 2 өргөдлийн хариуг хүргүүлэв.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын хүрээнд:

2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр аймгийн ГХУСАЗСЗөвлөлийн 2023 оны анхдугаар хуралдаан хуралдлаа. Хуралдаанаар 2022 оны ажлын тайлан хэлэлцэж, үйл ажиллагааны төлөвлөгөөг 95 хувийн гүйцэтгэлтэй буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэв.

2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөөг 13 зорилт 41 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр хэлэлцэн баталлаа.

ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлыг 1 дүгээр сард 2 удаа зохион байгуулж, 13 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Аймгийн ЗДТГ, хэлтэс агентлаг, сумдын Засаг дарга, сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ирүүлсэн 105 иргэний шагналын тодорхойлолтыг холбогдох байгууллагаас дүгнэлт авч аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжлав.

Аймгийн засаг даргын батламж гэрээ, Шадар сайдтай байгуулсан 2022 онд хамтарч ажиллах гэрээний хэрэгжилтийг гаргаж ЗГХЭГ, Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2023 онд Шадар сайдтай хамтарч ажиллах гэрээний төслийг боловсруулж шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн. Аймгийн ИТХ-ын ээлжит 14-р хуралдаанд хэлэлцүүлэх 10 асуудлыг холбогдох хэлтэс, байгууллагаас бэлтгэлийг хангуулж өргөн барьсан.

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхай зөвлөгөөнийг оны эхэнд батлагдсан хуваарийн дагуу 01 сарын 02, 16, 30-ны өдрүүдэд танхимаар зохион байгуулж, тэмдэглэлээр холбогдох байгууллага, суманд хүргүүлж, хэрэгжилт тооцов. Нэгдсэн шуурхайд өгөгдсөн үүргийг цахим үнэлгээний систем болох tov.unelgee.gov.mn-д оруулж, тайлагнаж байна.

“Иргэдтэй уулзах цаг” арга хэмжээний 2023 онд зохион байгуулах хуваарийг сар бүрийн эхний 7 хоногийн “Лхагва” гарагт буюу 12 удаа аймгийн Үйлчилгээний нэгдсэн төв, 5 удаа сумдад зохион байгуулахаар батлав. 01 сарын 04-ний өдөр “Иргэдтэй уулзах цаг” арга хэмжээнд аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, Зуунмод сумын Засаг дарга Ч.Сарангэрэл нар оролцож, 12 иргэний иргэдээс гаргасан санал, хүсэлт, асуултад хариулт өгч, шийдвэрлэв.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг танилцуулж, тэмдэглэлээр 3 заалт бүхий үүргийг холбогдох байгууллага, нэгж, сумдад хүргүүлэв. 2022 оны мэдээг хүснэгтээр харуулбал:

2022 онд иргэдээс Төв аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал /Өссөн дүнгээр/

№	Нэр	Нийт	Шийдвэрлэлт				Шийдвэр-лэлтийн хувь
			Шийдвэр-лэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	Аймгийн ИТХ	43	35	8	0	0	100
2	Аймгийн ЗДТГ	805	738	42	0	25	96,89
3	Сумд	15895	15221	112	135	427	97,31
4	Харьяа агентлаг, хэлтэс	2864	2782	49	8	25	99,13
Нэгдсэн дүн		19607	18776	211	143	477	97,57

2022 онд иргэдээс Төв аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдол хэлбэрээр /Өссөн дүнгээр/

№	Нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол	Үүнээс				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулзсан	Бусад
1	Аймгийн ИТХ	43	43	0	0	0	0
2	Аймгийн ЗДТГ	805	356	289	75	85	0

3	Сумд	15895	14742	280	134	708	31
4	Харьяа агентлаг, хэлтэс	2864	2674	144	19	27	0
Нэгдсэн дүн		19607	17815	713	228	820	31

2022 онд иргэдээс Төв аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдол агуулгаар /Өссөн дүнгээр/

Төв аймаг	Нийт 19607 өргөдлөөс 1. Хүсэлт 18026/ 91.93% 2. Гомдол 448/ 2.28% 3. Санал 1133/ 5.77% 1. Газартай холбоотой асуудлаар 5845 / 29.81% 2. Иргэний бүртгэлийн чиглэлээр 4852 /24.74% 3. Халамжийн үйлчилгээний чиглэлээр 2546/ 12.98% 4. Ажил, тусламж хүссэн 1205 / 6.14% 5. Нийгмийн даатгалын чиглэлээр 1074/ 5.47%
-----------	---

Аймгийн Засаг даргын А захирамж -1, Б захирамж -1, ЗДТГ-ын Б тушаал-15, А-тушаал-4 боловсруулж, гаргасан. ХНУМТ цахим системд албан хаагчдын мэдээллийг шинэчлэн оруулж байна. ТАЗөвлөлийн 600 дугаар тогтоолын дагуу албан хаагчдын хувийн хэргийн шинэчлэлт, баяжилтийг хийлгэх ажлыг эхэлсэн.

Аймгийн ЗДТГ-ын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт “Байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах” 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргасан.

Монгол Улсын Зам тээврийн хөгжлийн яам, Эрчим хүчний яаманд Авто тээвэр, Эрчим хүчний хяналтын Улсын байцаагчийн “Хяналтын улсын байцаагчийн эрх”-ийг олгуулахаар холбогдох бичиг баримтыг хүргүүлсэн. Байгууллагын албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөний төслийг боловсруулсан.

Төрийн албаны Төв аймаг дахь салбар зөвлөлд:

- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг үндэслэн 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд албан тушаалд томилогдсон албан хаагчдын судалгаа,
- Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдад зэрэг дэв олгуулах санал,
- Хууль эрх зүйн хэлтсийн Хууль зүйн туслалцаа, хууль тогтоомжийн системчлэл хариуцсан хуулийн мэргэжилтэн, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн сул орон тооны захиалга,
- Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 43 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус тус хүргүүлсэн.

Сумдын удирдлагын утасны жагсаалт, аймгийн төрийн байгууллагуудын утасны жагсаалтыг шинэчлэн нэмэлт өөрчлөлтийг хийж брошюр болгон хэвлүүлж, аймаг сумдын удирдлагад тараасан.

Аймгийн шууд харилцаат муж, хотуудад 2023 оны төлөвлөгөөг хүргүүлж, санал авсан. Аймгийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнүүлж, 2023 оны төлөвлөгөөг ИТХ-ын 14-р хурлаар батлуулав.

“ТӨВ АЙМАГ” апп-ийг аймагтаа хэрэглэнд нэвтрүүлэхээр бэлтгэж апп-ын эх загвар бэлэн болсон. Мөн аймгийн хэмжээнд 13 удаагийн цахим сургалтын холболтыг хийж үйл ажиллагааны тасралтгүй байдлыг ханган ажилласан.

ERP системд 27 агентлагийг байгууллагаар нь шинээр бүртгэл үүсгэж, ХХҮГ, БОАЖГ-т нэвтрүүлж эхэлсэн.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВИЙН ХҮРЭЭНД:

Аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт **16** байгууллага **600-аад** төрлийн үйлчилгээг **8261** иргэнд, өдөрт дунджаар **350-400** иргэнд хүргэн үйлчилсэн.

Цахим үйлчилгээний нэгдсэн систем /www.e-mongolia.mn/-ээр дамжуулан аймгийн хэмжээнд **1646** лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ҮНТөвийн операторуудаас **701** лавлагаа үйлчилгээ авсан байна. Мөн E-Mongolia үйлчилгээний тухай заавар зөвлөмжийг, төрийн үйлчилгээг цахимаар авч болох тухай мэдээ мэдээллийг **200-250** иргэнд хүргэж ажилласан.

Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд 11 гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжилсан.

Өөрөө өөртөө үйлчлэх цахим мэдээллийн буланд иргэд өөртөө үйлчлэх зориулалт бүхий газрын албаны киоск машин, төлбөр төлөлтийн “Гэрэгэ” киоск машинуудыг байршуулсан. Мөн Цахим үйлчилгээний нэгдсэн систем www.e-mongolia.mn, Газрын мэдээллийн нэгдсэн сангийн www.egazar.gov.mn, Аймгийн албан ёсны веб сайт www.tov.gov.mn, Аймгийн статистикийн хэлтсийн www.nso.gov.mn сайтуудыг холбосон 4 ухаалаг дэлгэцийг тус тус байршуулан иргэдэд цаг үеийн болон дотоод ажил үйлчилгээтэй холбоотой мэдээ мэдээллийг тогтмол хүргэж байгаа бөгөөд газрын нэгдсэн систем болох www.egazar.gov.mn сайтаар дамжуулан нийт 154 иргэн газрын талаарх үйлчилгээ авсан бол Гэрэгэ киоскоор дамжуулан 40 иргэн машины татвар, торгууль, улсын бүртгэлийн лавлагаа, жолоочын хариуцлагын даатгал, үүрэн телефоны нэгж авах зэрэг үйлчилгээнүүдийг авсан байна.

Мөн энэ сард манай төвд аймгийн удирдлагуудын Иргэдтэй хийх уулзалт болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын нээлттэй өдөрлөг тус тус болж нийт 71 иргэн хамрагдлаа.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХҮРЭЭНД:

Онцгой байдлын газраас 2022 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтэд дүгнэлт хийн, 2023 онд офицер бүрэлдэхүүний манлайлал, сахилга бат, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх зорилгоор офицер бүрэлдэхүүний сахилга, ёс зүйн зөвлөгөөнийг зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд Онцгой байдлын газрын сахилга, ёс зүйн зөвлөлөөс 2023 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, офицер бүрэлдэхүүн манлайлагч байх, бусдадаа үлгэр дурайл болох, цэргийн сахилгын дүрмийн зөрчилгүй хамт олон болох уриалгыг хэлэлцэн, харилцан санал солилцлоо.

Онцгой байдлын газрын алба хаагчид болон анги салбарын захирагч нар газрын даргатай 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлууллаа. Төв аймгийн Баян, Эрдэнэ сумдад 2018-2022 онд тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас учирсан хохирол, нас барсан хүн, ажилласан хүн, техник, хэрэгслийг судалгааг нэгтгэж Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлсэн.

Шинээр томилогдсон алба хаагчдын цол олгох тангараг өргөх ажиллагааг зохион байгууллаа.

Онцгой байдлын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 13 ний өдрийн А/01 тоот 2023 оны “Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах” тухай тушаал гарч нийт алба хаагчдад сургалт бэлтгэл орж эхэлсэн. Онцгой байдлын ерөнхий газрын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны 3/05 дугаар албан бичгийн хүрээнд гал унтраах автомашины жолооч бүрэлдэхүүн Renaulty D15 E3 загварын гал унтраах автомашины гал унтраах усан хөөрөг /насос/-ийг ажиллуулах зааврын дагуу дадлага сургалтыг явуулж, үйл ажиллагаандаа мөрдүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайдын баталсан аймгийн Зуунмод сумдад үйл ажиллагаа эрхэлж буй Худалдаа олон нийт, үзвэр үйлчилгээ, цахим тоглоомын газруудад галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу Төв аймгийн Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч ахмад А.Бэх-Очир, ахмад Г.Отгонбаатар нар Зуунмод сумдад үйл ажиллагаа эрхэлж буй Худалдаа олон нийт, үзвэр үйлчилгээ, цахим тоглоомын 12 байгууллагын барилга байгууламжид төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2023 оны 01 дүгээр сарын 02-оос 01 дүгээр сарын 20-ыг хүртэлх өдрүүдэд зохион байгуулав.

Төлөвлөгөөт хяналт шалгалтаар 12 Худалдаа олон нийт, үзвэр үйлчилгээний барилга байгууламжийг хамруулан нийт 92 зөрчил дутагдлыг илрүүлж, газар дээр нь 16 зөрчлийг арилгуулж, бусад 76 зөрчил дутагдлуудыг арилгуулахаар байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 10, мэдэгдэл 2 хүргүүлж, шалгалтын дүнгийн талаар шалгалтад хамрагдсан газрын удирдлагууд болон ажилчдад танилцуулж, Галын аюулгүй байдлын тухай хуулиудад заагдсан эрх үүрэг, илэрч байгаа зөрчлүүдийг арилгах талаар мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллав.

Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/09 дүгээр тоот захирамжаар Архуст, Баяндэлгэр, Мөнгөнморьт, Эрдэнэ сумдад ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж өвөлжилт хүндэрсэн, хүндэрч болзошгүй сумдын бодит нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж ажиллаж, илтгэх хуудас бичиж ажлын хэсгийн ахлагчид танилцуулан ажилласан.

Орон нутгийн гамшгаас хамгаалах албад шалгах төлөвлөгөөт хяналт шалгалтын хуваарийг Онцгой байдлын газрын даргаар батлуулж, хүргүүлсэн. Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг 2023 онд Заамар, Жаргалант, Архуст сумдад зохион байгуулах график төлөвлөгөөг Онцгой байдлын газрын даргаар батлуулж, сумдад хүргүүлсэн.

2023 оны Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүний цугларах дохиогоор ажиллах, автомашин, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.

Архуст, Баянжаргалан, Борнуур, Лүн, Зуунмод, Эрдэнэ, Эрдэнэсант сумдын Зудын гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө, Заамар сумын Монполимонт ХХК-ийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тус тус хянасан. Баянчандмань, Төв, Налайх АЗЗА ТӨХК-д гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2023 оны 03/01, 03/02, 03/03 дугаар

тодорхойлолт гаргаж өгсөн. Төв аймгийн 2022-2023 оны өвөлжилтийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг Улаанзагалмайн нийгмийн Төв аймаг дахь дунд шатны хороо, Японы хүүхдийг ивээх санд хүргүүлэн ажилласан.

Төв аймаг дахь Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд 2022 онд тохиолдсон аюулт үзэгдлийн тоо мэдээг, учирсан хохирол, өмнөх онтой харьцуулсан байдлыг нэгтгэж хүргүүлсэн.

Онцгой байдлын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр баталсан удирдамжийн хүрээнд Баянчандмань, Лүн сумдад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад гамшиг осол болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт зохион байгуулж ажиллав. Тус шалгалтад Баянчандмань, Лүн сумдын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид Гамшигийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгээгүй, Зарлан мэдээлэх дохио байрлуулаагүй, гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл байрлуулаагүй, нэг бүрийн хяналтын карт хөтлөөгүй, Гал унтраах автомат тоног төхөөрөмж галын дохиоллын систем стандартын дагуу байрлуулаагүй, ажилтан албан хаагчдад гал түймэртэй тэмцэх, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга ажиллагаанд сургах зэрэг зөрчил дутагдлууд илэрч байгаа тул мэргэжлийн зөвлөн туслах, заавар, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлж нийт 38 байгууллага хамрагдаж гал түймэр гарч болзошгүй болон гарсан үед хариу арга хэмжээ авах 144 зөрчил илрүүлж газар дээр нь засах боломжтой 32 зөрчил арилгуулж 112 зөрчил дутагдалд байгууллагын удирдах албан тушаалтан болон холбогдох иргэдэд сургалтыг зохион байгуулан ажиллалаа. Зөрчил заагдсан байгууллагад Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн эрх зүйн баримт бичиг хүргүүлэн зөрчлийг арилгуулах шат дараатай арга хэмжээ авахаар шийдвэрлэлээ.

Хяналт шалгалтад хамрагдаж, галын аюулгүй байдал нь хангагдсан 3 аж ахуй нэгж байгууллагад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт, зөвшөөрөл олгов.

Аюулт үзэгдэл, ослын төрөл тус бүрт урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах талаар онол, практикийн мэдлэг, чадвартай алба хаагчдыг бэлтгэх зорилгоор ангиллын сургалт зохион байгуулах удирдамж гарган, Онцгой байдлын газрын урьдчилан сэргийлэх тасгийн алба хаагчид, мэргэжилтэн нарт танхим хэлбэрээр зохион байгуулж 10 удаагийн 20 цагийн сургалтаар 251 ажилтныг хамрууллаа. Үүнд: Архуст, Баяндэлгэр, Мөнгөнморьт, Эрдэнэ, Баянчандмань, Лүн сумдын сумын Онцгой комиссын гишүүдэд “Гамшигийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар”, “Зудын нөхцөл байдал, сумын Онцгой комиссын авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдвүүдэд 12 цагийн танхимын сургалтыг зохион байгуулж, 182 хүнийг хамруулсан. УБЦТС ТӨХК-ны Зуунмод түгээх төвийн нийт 52, Хүнс, хөдөө аж ахуйн газрын 17 нийт 69 ажилчдад “Гамшгаас хамгаалах тухай хууль”, “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-аар танхимын сургалт зохион байгуулсан.

Онцгой байдлын газраас сар бүр бэлтгэн хүргэдэг “Онцгой байдлын цаг” нэвтрүүлгийн 2023 оны 01 дүгээр сарын дугаарыг бэлтгэн олон нийтэд хүргэсэн.

Орон нутгийн TBS телевизээр цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн үед хол замд зорчихгүй байх, бэлтгэл бэлэн байдлаа сайтар хангах, дулаан хувцаслах, баталгаат зам гүүр, маршрутаар явах, Онцгой байдлын байгууллагаас өгч буй заавар зөвлөмжийг хэрэгжүүлэх сэрэмжлүүлэг мэдээллийг цаг тухай бүр телевизээр дамжуулан ард иргэдэд өдрийн 3 удаагийн давтамжтайгаар нийт 75 удаа хүргэн ажилласан.

Бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэрт нь цоожлон үлдээхгүй байх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж гэр, орон сууцны цахилгааны аюулгүй байдлыг хангаж, үр хүүхдийнхээ аюулгүй орчинг цаг ямагт бүрдүүлж байх чиглэлээр “Ахуйн хүрээний ослоос урьдчилан сэргийлье” сэрэмжлүүлэх мэдээллийг бэлтгэж, TBS телевизээр ард иргэдэд өдрийн 4 удаагийн давтамжтайгаар нийт 100 удаа хүргэн ажилласан.

Онцгой байдлын газрын 5200 дагагчтай фейсбүүк хуудсанд 13 удаагийн мэдээ мэдээлэл байршуулж, веб сайтад сэрэмжлүүлэг мэдээг 2 удаа, иргэдэд чиглэсэн зөвлөгөө зөвлөмжийг 2 удаа, байгууллагын үйл ажиллагаа, сургалт, хяналт шалгалт явуулсан талаарх мэдээ мэдээллийг 7 удаа нийт 11 удаагийн мэдээ мэдээллийг байршуулан иргэдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа.

Мөн байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээний постер, бичлэгүүдийг цаг тухай бүр хийн нийт 4 төрлийн постер 2 төрлийн видео бичлэгийг байршуулсан.

Тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын талаар

Малын гоц халдварт өвчин: Хорио цээрийн дэглэм тогтоосон Баянчандмань-1, Баян-1.

Гал түймрийн нөхцөл байдал: Объектын гал түймэр-3, мэдээлэл-1, ой, хээрийн түймрийн дуудлага байхгүй.

Аврах ажиллагааны дуудлага: Эрэн хайх аврах ажиллагаа-4.

Монгол Улсад Гал түймэртэй тэмцэх байгууллага үүсэн байгуулагдсаны түүхт 101 жилийн ойн баярын угтан Онцгой байдлын газрын алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, гэр бүлийн нөхөрсөг, уулзалт "Мөнгөн өвөл" цасны баярын арга хэмжээг зохион байгуулав.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Монгол Улсны Үндсэн Хуулийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргын хамтарсан удирдамжийн дагуу аймгийн ИТХ-ын Ажлын албаны албан хаагчидтай хамтран дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Шинэ Үндсэн Хууль батлалцсан депутатуудад хүндэтгэл үзүүлж, Чингис хааны музей үзүүлсэн. Парламент видео подкаст, АИХ-ын депутатуудын дурсамж яриаг орон нутгийн телевизээр иргэдэд хүргэж сурталчилж, “Үндсэн хууль ба Нийгэм” сэдэвт лекцийг “Иргэдийн шударга шүүх” ТББ-тай хамтарч төрийн албан хаагчдын дунд зохион байгуулсан.

Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийн 2022 оны бүрдүүлэлтийн ажил эхэлсэнтэй холбогдуулан аймгийн ИТХ-ын Ажлын албатай хамтран сум, байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудад арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг цахимаар зохион байгууллаа. Сургалтаар ХАСХОМ шинэчлэн гаргах, хүлээн авсан бүртгэл”, Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүртгэл”, “Мэдэгдэл, тайлбар, тэдгээрийн шийдвэрлэлтийн бүртгэл” болон бүрдүүлэлтийн үйл ажиллагаа, цахим системд мэдээлэл нэгтгэхэд анхаарах асуудлаар чиглэл өглөө.

Авлигын эсрэг хуулийн хүрээнд хувийн ашиг сонирхлын хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагчдын мэдээллийг нэгдсэн байдлаар хүлээн авч байна. Аймгийн хэмжээнд нийт 431 мэдүүлэгч мэдүүлэхээс 117 мэдүүлэгч мэдүүлгээ баталгаажуулсан байна. Удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу 10 албан бичгийн төсөл боловсруулж, холбогдох газарт хүргүүлсэн. Орон нутгийн өмчийн газар, Засаг даргаас ирүүлсэн 2 гэрээний төслийг бэлтгэсэн. Засаг даргын 3 захирамжийн төсөлд авлига хариуцсан мэргэжилтний хувиар хянаж гарын үсэг зурсан. Зардал гаргах тухай Засаг даргын 1 захирамжийн төслийг бэлтгэж, албажуулсан. Засаг даргын захирамжаар ажлын хэсэгт нарийн бичгийн даргаар орж ажиллан, ажлын хэсгийн гишүүдийн хамт холбогдох дүгнэлтийг гаргаж Засаг даргад танилцууллаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг сурталчлан таниулах, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, худалдан авах ажиллагааны мэргэжилтэн бэлтгэх, төсвийн ил тод байдалд иргэд, олон нийтийн оролцоог хангах зорилгоор Төв аймгийн Засаг даргын Тамгын газар, Орон нутгийн өмчийн газар, Сайн худалдан авалтын зөвлөх төрийн бус байгууллагатай хамтран “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ” сургалтыг 2023 оны 01 дүгээр сарын 14-16-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагууд болон сумдын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагын нийт 103 албан хаагч, иргэний төлөөлөл хамруулан, аймгийн Төв, Зуунмод суманд зохион байгуулаа. Тус сургалтаар -Засгийн газрын худалдан авах ажиллагааны эрх зүйн орчин -Тендерийн жишиг баримт бичиг боловсруулах -Тендер шалгаруулалтын журмын талаар -Тендерийн урилга, техникийн тодорхойлолт бэлтгэх -Худалдан авах ажиллагааны хяналт, зохицуулалт -Тендерийн үнэлгээ, үнэлгээний зарчим гэх мэт худалдан авах ажиллагааны талаар эрх зүйн мэдлэгийг дээшлүүллээ. Худалдан авах ажиллагааны АЗ шалгалтад 60.5 хувь тэнцэж үнэлгээний хороонд ажиллах эрхтэй боллоо.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2023 оны 02/21 дугаартай албан бичгийн дагуу аймгийн хэмжээнд бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрх зүйн хөтчийн 2022 оны үйл ажиллагааны тайланг хүргүүлсэн.

Төрийн архивын дэргэдэх БНШАЗК-ын хурал 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр хуралдаж 30 байгууллагын байнга, түр хадгалах бүртгэл, устгах хэргийн актыг хэлэлцэн, 28 байгууллагын ХХНЖ, бүртгэлийг хянан, зөвшөөрч, 2 байгууллагад албан тоотоор зөвлөмж хүргүүлээ.

Төрийн архивын хөмрөг үүсгэгч 159 байгууллагын архивын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээг нэгтгэн Архивын ерөнхий газарт хүргүүллээ.

Төрийн архивын тасгаас Зуунмод сумын ЗДТГ, Хот тохижуулах газар, Цаг уур, орчны шинжилгээний төв, Ойн анги, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Соёлын газар, Музей, Номын сан, ХХААГ, ГБХЗХГ, ГХБХБГ, Заамар сумын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Баян, Борнуур, Бүрэн, Лүн, Цээл, Аргалант сумын ЗДТГазар нийт 18 байгууллагын архив, албан хэрэг хариуцсан ажилтнуудад танхим болон цахимаар Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 7 дугаар зүйлд заасны дагуу ХХНЖ боловсруулах чиглэлээр, мөн 63 хөмрөг үүсгэгч байгууллагад архивын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээ гаргах талаар зөвлөн тусалсан.

ТӨРИЙН АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Төрийн архивын эх баримтаас лавлагаа, хуулбар авах хүсэлт ирүүлсэн 97 иргэний хүсэлтийг хүлээн авч 476 хуулбар хувь олгож, 43 лавлагаа, 469 хөмрөгийн 320 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан үйлчилгээ үзүүллээ.

1 хөмрөгийн 43 хадгаламжийн нэгжийн 1399 хуудас баримтын 1502 хүний нэр, 357 заалтын тоо, 357 тушаалын тоог мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, 13 хадгаламжийн нэгжийн 1150 хуудас баримт скайнердаж 357 заалтыг PDF.JPEG хэлбэрт хувиргаж, 357 заалтын 1399 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэлээ.

Баримтын нөхөн бүрдүүлэлтээр хувийн хэвшлийн аж ахуйн нэгж болон байгууллага, иргэдээс ирүүлсэн нийт 129 баримтыг хүлээн авч, баримтын тоо бүртгэл хөтлөн хадгаламжийн санд бүртгэж авлаа.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 65733 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 138543 газар өмчлөх эрхийн 53.921 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 1322 (1 дүгээр сард хүлээн авсан мэдүүлэг-1322)

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос 2023 оны 1 дүгээр сарын байдлаар нийт 10,9 төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 34,1 төгрөг, тэмдэгтийн хураамжаас 778600 төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 2934 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 39 нэмэлт өөрчлөлт, шинээр 17 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 1, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 6 бүртгэл хийгдсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 4 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 6 лавлагаа өглөө. Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн орлого нийт 2.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2022 оны эхний 12 сард 877 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оноос 266 хэргээр буюу 44 хувиар өсч, гэмт хэргийн илрүүлэлт 65 хувьтай, өмнөх оноос 6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Эрүүлжүүлэх, саатуулах байранд гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, ар гэртээ согтуугаар танхайрсан зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн-6, шүүхээр баривчлагдсан-48, албадан саатуулсан-7, ар гэрт нь 4 иргэнийг хүлээлгэн өгч, нийт 61 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд код журмын дагуу биед эрүүл мэндийн үзлэг хийж, хүлээн авч ажиллалаа. Шүүхээр баривчлагдаж хугацаа дуусаж, гарсан 52 иргэний төлбөр 2,6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

Улаанбаатар хотод болсон нийтийг хамарсан жагсаал, цуглааны үеэр Төв аймаг дахь Цагдаагийн газрын 60 алба хаагч, 6 тээврийн хэрэгсэлтэй ажиллаж олон нийтийн аюулгүй байдлыг хангалаа.

2022 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүртэл согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож, замын хөдөлгөөнд оролцсон 45 жолоочийг илрүүлж, 39 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцсон 6 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллийг бүртгэж ажиллалаа.

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөннийг 3063 жолоочийг 80.092.900 /наян сая, ерэн хоёр мянга, есөн зуун/ төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 53 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатууллаа.

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2023 оны эхний 01 дүгээр сарын байдлаар 81 гэмт хэрэг бүртгэж, гэмт хэргийн илрүүлэлт 13,5 хувьтай байна.

Эрүүлжүүлэх, саатуулах байранд гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, ар гэртээ согтуугаар танхайрсан зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн-6, шүүхээр баривчлагдсан-45, албадан саатуулсан-10, ар гэрт нь 6 иргэнийг хүлээлгэн өгч, нийт 61 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд код журмын дагуу биед эрүүл мэндийн үзлэг хийж, хүлээн авч ажиллалаа.

Шүүхээр баривчлагдаж хугацаа дуусаж гарсан 45 иргэний төлбөр 1.314.950 төгрөг эрүүлжүүлэгдсэн 6 иргэний 24900 төгрөг нийт 1.339.850 төгрөгийг төрийн сангийн 100140012001 тоот дансанд бүрэн тушаалаа.

Баян сум Бүрд 3-р баг “Майхан” гэх газар 1 иргэний хотонд малын “Мялзан” өвчин 3 малаас илэрч 5 мал өвчилж 2 мал хорогдож ЗДТГ-1, ЦАХ-1, Улаанбаатар хотод болсон нийтийг хамарсан жагсаал, цуглааны үеэр 12-р сарын 5, 6-ны өдрүүдэд цагдаагийн 60 алба хаагч, 6 тээврийн хэрэгсэлтэй ажилласан мөн Олон нийтийг хамарсан 4 удаагийн арга хэмжээнд 8 алба хаагч, 4 тээврийн хэрэгсэлтэй 24 цагийн үүрэг гүйцэтгэж ажилласан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гудамж замын хяналт шалгалтаар 6038 зөрчил илрүүлж, Монгол улсын Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.1, 5 дахь заалтуудыг зөрчиж согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 75 жолоочийг илрүүлэн тээврийн хэрэгслийг түр саатуулсан.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 63 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, хуульд заасны дагуу 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ

согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон 12 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэвэрээр 7-30 хоног баривчилуулж, Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 89 жолоочийг илрүүлж, Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллэлд бүртгэсэн.

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 5848 жолоочийг 162.802.650 /нэг зуун жаран хоёр сая найман зуун хоёр мянга зургаан зуун тавь/-н төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 65 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулсан.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Криминалистикийн шинжилгээ-6, магадлан шинжилгээ-20, хэргийн газрын үзлэгт оролцсон тоо-46, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-90, гарын хээний санг дардсаар баяжуулсан-17, мөрөөр баяжуулсан-0, гэмтлийн зэрэг тогтоосон дүгнэлт-67, ДНК-ийн мэдээллийн сангийн баяжилт-20, гистологийн шинжилгээ-20 тус тус хийгдлээ.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
1-р сар	309	52	3	358	38	320	10,6
	4857937.6	1346136.5	125869.0	6078205.1	300608.4	5777596.7	

ДӨРӨВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХҮРЭЭНД:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, харьяа байгууллагын төсвийн шууд захирагч нарын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталлаа.



2. “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явцын тайлан болон аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж үнэлэх, хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн түвшингээр тодорхойлж үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдсэн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмжийг гаргалаа.

3. Сумдын 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнг тооцож Монгол Улсын хууль тогтоомж, төрийн бодлого шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг орон нутагт амжилттай хэрэгжүүлэн 2022 оны үйл ажиллагааны үр дүнгээрээ Эрдэнэ, Зуунмод, Алтанбулаг, Дэлгэрхаан, Эрдэнэсант сумд тэргүүлээ.

4. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2022 оны А/300 тоот захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу 36 шийдвэрийн 119 заалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2022 оны жилийн эцсийн байдлаар 95.64 хувийн хэрэгжилттэй Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүллээ. Үүнээс:

	Нийт	МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	ҮАБЗ-ийн зөвлөмж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	36	8	2	2	5	8	5	1	4	1
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	119	68	2	2	14	14	8	1	9	1
Бүрэн хэрэгжсэн	100%	55	1	2	13	13	7	-	8	1
Хэрэгжих шатанд	70%	11	1	-	1	1	1	1	1	-
Хэрэгжилт хангалтгүй	30%	-	-	-	-	-	-	-	-	-
Хэрэгжээгүй	0%	-	-	-	-	-	-	-	-	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Х.Б	2	2	-	-	-	-	-	-	-
Биелэлтийн дундаж	95.64%	95%	85%	100%	97.86%	97.86%	96.25%	70%	96.67%	100%

Хэрэгжилт гаргах нийт заалтын тоо			119
1	Бүрэн хэрэгжсэн	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	100% 100
2	Хэрэгжих шатанд	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	70% 17
3	Хэрэгжилт хангалтгүй	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	30% -
4	Хэрэгжээгүй	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	0% -
5	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	Х.Б 2
Хэрэгжилтийн дундаж			95.64%

Санхүүгийн хяналт, дотоод аудитын чиглэлээр:

2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад ОНХС, ХХС, ЭЭС-ийн үйл ажиллагаанд дотоод аудит, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт шалгалт хийж 546,767.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 9,364.5 төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн акт, 537,402.8 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага өгч ажиллаа. Өмнөх онуудын актын үлдэгдэл 190,473.4 мянган төгрөгийн актын үлдэгдлээс 3,775.7 мянган төгрөг барагдсан байна.

ТАВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХҮРЭЭНД:

Төсвийн орлогын талаар:

Орлогын төлөвлөгөө жилийн эцсийн байдлаар орон нутаг 28948,5 сая төгрөг төвлөрүүлэхээс 36974,6 сая төгрөг төвлөрүүлж 127,7 хувьтай, 8026,1 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө давсан байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 6781,1 сая төгрөг төвлөрүүлэхээс 9554,1 сая төгрөг төвлөрүүлж 140,9 хувьтай, 2772,9 сая төгрөгөөр давж биелсэн. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 11272,8 сая төгрөгөөр биелж, 127,9%-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Батсүмбэр, Баян-Өнжүүл, Баянцагаан, Эрдэнэ, Зуунмод зэрэг 5 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Алтанбулаг, Аргалант, Баян, Баяндэлгэр, Баянжаргалан, Баянхангай, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Дэлгэрхаан, Заамар, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сэргэлэн, Сүмбэр, Угтаал, Эрдэнэсант зэрэг 18

сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Архуст, Бүрэн, Жаргалант зэрэг 3 сум, 3 шатны орлогын төлөвлөгөө тасалсан Цээл сум байна.

Төсвийн зарлага, санхүүжилтийн талаар:

Сумдад 2022 оны 12 дугаар сарын байдлаар нийт 63969.5 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Орон нутгаас Боловсрол шинжлэх ухааны байгууллагад 11173.9 сая төгрөгийн санхүүжилт

Эрүүл мэндийн байгууллагад 829.4 сая төгрөгийн санхүүжилт

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 29860.5 сая төгрөгийн санхүүжилт

Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 22105.7 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгоод байна.

Өр, авлагын талаар:

2022 оны 12-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 187.7 сая төгрөгийн авлага, 225,7 сая төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 182,5 сая төгрөг буюу 80.9 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 1.3 сая төгрөг буюу 0.6 хувь нь цалингийн өглөг, 1.8 сая төгрөг буюу 0.8 хувь нь НДШимтгэлийн өр, 9.6 сая төгрөг буюу 4.3 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, үлдсэн 30.3 сая төгрөг буюу 13.4 хувийг бусад өр эзэлж байна

ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн хэмжээнд 2023 онд **170,4 тэрбум** төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэхээр төлөвлөгдлөө. Үүнд:

- Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжих 144,3 тэрбум төгрөгөөр санхүүжих 49 төсөл, арга хэмжээ тусгагдаж 32 төсөл арга хэмжээний эрх шилжиж ирээд байна.

- Орон нутгийн хөгжлийн сангаар 7,6 тэрбум төгрөгийн 27 төсөл, арга хэмжээ

- Аймгийн төсвийн шилжих үлдэгдлийн хөрөнгө оруулалтаар 6,1 тэрбум төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ

- Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 1,2 тэрбум төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ

- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,8 тэрбум төгрөгийн 8 барилга, их засвар

- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 0,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 төсөл, арга хэмжээ

- 27 суманд хуваарилагдсан орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээр 8,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр тус тус тусгагдлаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 21,423.3 сая төгрөгийн 78 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг тусган баталж үүнээс 15,980.7 сая төгрөгийн 62 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн. Үүнд:

1. Аймгийн Шилжих үлдэгдэлийн хөрөнгө оруулалтын 665.6 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ;

2. Аймгийн Замын сангийн хөрөнгө оруулалтын 2,731.4 сая төгрөгийн 4 ажил;

3. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 7,758.6 сая төгрөгийн 43 төсөл, арга хэмжээ;

4. Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 982.3 сая төгрөгийн 5 ажил;

5. Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 343.0 сая төгрөгийн 7 ажил;

6. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, 27 сумын 2023 оны эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах 3,500.3 сая төгрөгийн бараа худалдан авах.

2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 01 дүгээр сарын явцын мэдээллээр захиалагч байгууллага болох аймгийн Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газраас дараах ажлуудын үнэлгээний хороог байгуулж ирүүлсэн дагуу үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг эхлүүлэх талаарх эхний хурлаа товлож, тендерийн баримт бичиг боловсруулахаар ажиллаж байна. Үүнд:

1. Зуунмод цэнгэлдэх хүрээлэнгийн барилдааны талбайд таримал хуйлмал зүлэг суурилуулах ажил;

2. Нийтийн орон сууцны подвалын бохирын шугам сүлжээнүүдийг шинэчлэх (Зуунмод 19, 20, 21, 22 байр);

3. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн сүүдвэрчийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил.

Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын зөвлөлд 2023 оны 01 дүгээр сарын 24-нд танилцуулж ажиллалаа.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Барилга, хот байгуулалтын чиглэлээр аймгийн хэмжээнд 2022 онд хийгдсэн болон 2023 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг гарган холбогдох газруудад хүргүүлж ажиллалаа. Үүнд: Монгол улсын барилга, хот байгуулалтын яамны 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 3/121 тоот албан бичгийн дагуу барилгын техникийн хяналтын чиглэлээр 2023 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх 15 объектын эрсдэлийг үнэлэж, холбогдох газар хүргүүллээ.

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 402 дугаар тушаалаар батлагдсан “Хот тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар”-ын дагуу 2022 онд хийгдсэн жижүүрийн хөтлөлтийн тайланг хэвлэмэл болон тоон байдлаар гарган Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлж тайлагналаа.

Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд нийт 2023 онд 4 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан баталж олголоо.

Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар 12 -ыг боловсруулан баталж Боловсрол соёл шинжлэх ухааны яаманд хүргүүллээ.

Зураг төсөл зөвшөөрөлцөх баталгаажуулах шатанд байршилыг ерөнхий төлөвлөгөөний хүрээнд батлах, орон нутгийн саналыг зурагт тусгах зэрэг ажлыг хийж 2023 онд нийт 10 зураг төсөл зөвшөөрөлцөөд байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар Борнуур сумын услалтын системийн далангийн толгойн барилгын хуваарилах, нөөцлөх хэсэгт гарсан эвдрэлийг шалгах ажлын хэсэг байгуулж ажлын хэсэг 2023 оны 01 дүгээр сарын 27-ний өдөр ажиллаж дүгнэлт гаргах шатандаа байна.

Зуунмод хотын дулаан хангамж, цэвэр усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, нийтийн орон сууцны доторхи шугам сүлжээнд засвар, шинэчлэл хийх ажлын эрэмбэ дарааллыг тогтоохоор аймгийн засаг даргын захирамжаар ажлын хэсэг гарч ажлын хэсгээс шугам сүлжээний эрэмбэ дарааллыг тогтоон нэгдсэн дүгнэлтийг гаргахаар ажиллаж байна.

ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг Баянхангай сум 1 нэгж талбар, төсөл сонгон шалгаруулалтыг Баянхангай сум 21 нэгж талбарт газрын биржийн www.mle.mn сайтад баталгаажуулж, зарлаад байна. 2022 оны Газрын нэгдмэл сангийн газрын төлбөрийн ГТ8, болон ГТМ2 тайланг 27 сумаас авч нэгтгэн ГЗБГЗЗГазарт хүргүүллээ.

2023 оны газрын төлбөр, татварын ногдуулалтыг уншуулж, нэхэмжлэлийг үүсгэх ажил хийгдэж байна. 2023.01.25-ны өдрийн байдлаар газрын төлбөрийн орлогоос 70,3 сая төгрөг сумдын төсөвт төвлөрөөд байна. 2023 оны 01 сарын 15-ны өдөр Газрын нэгдмэл сангийн тайлан болох ГТ-2, ГТ-3 болон зөрчилтэй нэгж талбарын тайланг 27-н сумаар нэгтгэж Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүллээ. Батсүмбэр, Баянчандмань, Эрдэнэ сумын нийт 24 нэгж талбарын топлоги алдааг засварлаж, зөрчлийг арилгалаа.

Газрын нэгдмэл сангийн тайлан ГТ6, ГТ7 маягт-ын дагуу хохирол, газар хамгаалах нөхөн сэргээх шаардлагатай газрын газар зүйн мэдээллийн систем ArcGis программ дээр боловсруулалт зургийг хийж ГЗБГЗЗГазарт Суурь судалгаа газрын мониторингийн хэлтэст хүргүүлсэн.

Газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг Газрын мониторингийн цахим системээр хүлээн авч баталгаажуулан ажиллаж байна. 2023.01.25-ны өдрийн байдлаар 12 мэдэгдэх хуудас хэвлэж өгснөөс 3 захиалгат хянан баталгааны тайланг цахимаар ирүүлээд байна.

Геодези, зураг зүйн ажлын хүрээнд:

Заамар сум Ай Би Би Ай, Редбулкан ХХК 2022 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг хэмжиж зураглалыг гаргалаа.

Газрын нэгдмэл сангийн ГТ-1,5 тайланг сумдаас авч нэгтгэн ГЗБГЗЗГазарт хүргүүллээ.

Геодези зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлгийг Зуунмод суманд зохион байгууллаа.

Газар зохион байгуулалтын ажлын хүрээнд:

Газар нэгдмэл сангийн ГТ-9 газар өмчлөлийн тайланг хугацаанд ГЗБГЗЗГазарт хүргүүллээ. Засгийн газрын 2022 оны 121 дугаар тогтоолд Төв аймгийн хэмжээнд шинээр өмчлүүлэх газрын хэмжээг 4709 иргэнд 1420,25 га, эзэмшиж буй газрыг өмчлүүлэх 931 иргэнд 65,06 га, улсын чанартай авто зам дагуу өмчлүүлэх 559 иргэнд 39,13га, аж ахуйн зориулалтаар иргэнд үнээр нь өмчлүүлэх 1 иргэнд 0,1709 га, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнээр өмчлүүлэх 40 иргэнд 0,7 га газрыг өмчлүүлэхээр батлагдсан. Тайлант онд шинээр өмчлүүлэх газрын хэмжээг 4709 иргэнд 1420,25 га, эзэмшиж буй газрыг өмчлүүлэх 931 иргэнд 65,06 га, улсын чанартай авто зам дагуу өмчлүүлэх 559 иргэнд 39,13га, аж ахуйн зориулалтаар иргэнд үнээр нь өмчлүүлэх 1 иргэнд 0,1709 га, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнээр өмчлүүлэх 40 иргэнд 0,17 га газрыг төлөвлөснөөс шинээр өмчлүүлэх 1715 иргэнд 489,25 га, эзэмшиж буй газрыг өмчлүүлэх 55 иргэнд 10.76 га, улсын чанартай авто зам дагуу өмчлүүлэх 355

иргэнд 25.16 га, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнээр өмчлүүлэх 9 иргэнд 0,15 га нийт 2134 иргэн 525,32 га газрыг өмчлүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 74940 иргэнд 13822,18 га газрыг өмчлүүлж, газар өмчлөлийн явц 79 хувьтай байна.

Газар зохион байгуулалт, хот байгуулалтын цахим системд 27 сумын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 10389 нэгж талбар 297075.56 га талбай төлөвлөснөөс газар чөлөөлөх 12 нэгж талбар 6369,23 га, дуудлага худалдаагаар 271 нэгж талбар 1149,74 га нийтийн эдэлбэр газрын төлөвлөлт 33 нэгж талбар 4467,38 га, нөхөн сэргээх, хамгаалах 45 нэгж талбар 267907,87 га, төсөл сонгон шалгаруулалт 52 нэгж талбар 905,5 га, газар өмчлөл 6240 иргэнд 1525,311 га, гэр бүлийн хэрэгцээ, зуслан, төсөвт байгууллага, давуу эрхээр 3736 нэгж талбар 14750,53 га газар төлөвлөснөөс энэ онд дуудлага худалдаагаар 98 нэгж талбар 357.30 га, нийтийн эдэлбэр газрын төлөвлөлт 26 нэгж талбар 4421,03 га, нөхөн сэргээх, хамгаалах 8 нэгж талбарын 101379,38 га, төсөл сонгон шалгаруулалтаар 36 нэгж талбарын 774,72 га, газар өмчлөл 2610 иргэнд 714.87 га, гэр бүлийн хэрэгцээ, зуслан, төсөвт байгууллага, давуу эрхээр 1600 нэгж талбар 4964,63 га нийт 4378 нэгж талбарын 112612 га газрыг олгож, бүртгэсэн байна.

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд 27 сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний арга хэмжээний 11032 нэгж талбар бүрээр оруулж сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг цахимд системд баталгаажуулж байна.

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 52 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 07 дугаар сарын 20-ны өдрийн А/396 дугаар захирамжаар хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох санал, холбогдох баримт бичиг, өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт хурлын тэмдэглэлийг тус тус судлан үзэж 3 байгууллагын 400.0 сая төгрөгийн хөрөнгийн үнэ болон хугацааг шинэчлэн тогтоосон.

Эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын архивын баримт бичгийг орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой 60 байгууллагаас авч хяналтын хуудсыг баталгаажуулан архивын нэгж үүсгэж байна.

Аймгийн Засаг даргын удирдах зөвлөлийн хурлаар Хөрөнгө шийдвэрлэх тухай 3 асуудлыг танилцуулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын удирдлагын зөвлөлд өргөн барьж хэлэлцүүлээд байна.

Засгийн газрын шийдвэрийн дагуу Орон нутгийн өмчит бүртгэлтэй Мэргэжлийн хяналтын газрын барилга байгууламж, холбогдох зарим эд хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүлээн аваад байна. Цаашид ашиглагч байгууллагаар аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс тус тус байрлан үйл ажиллагаагаа эрхлэн явуулахаар шийдвэрлэлээ.

“Төв Чандмань” ДЭХГ ОНӨААТҮГ, “Зуунмод цэцэрлэгжүүлэлт” ОНӨААТҮГ -ын удирдах зөвлөлийн хуралдаанаар 2023 оны төсвийг хэлэлцсэн ч дахин нягтлан судлаж танилцуулахаар түр хугацаагаар хойшлуулаад байна.

Аймгийн “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын хүрээнд 2018 онд түрээсийн 12 өрх, 2019 онд 13, 2021 онд 1 өрх нийт 26 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулснаар сарын график хугацааны төлөлтөд хяналт тавьж ажилласнаар 2019-2023 оны 01 дүгээр сарын 25-ны байдлаар нийт 150,459,940 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Баяндэлгэр сумын ЗДТГ, “ӨВ-МЕНЕЖМЕНТ” ХХК-ийн хооронд үүссэн цэвэр усны нэгдсэн шугамын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байгаа талаарх маргааныг нягтлан судлан үзэж дүгнэлт гаргахаар ажиллаж байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Газар тариалангийн хүрээнд: Газар тариалангийн үйлдвэрлэлд сүүлийн 3-н жилийн үзүүлэлт, эргэлтийн талбайн ашиглалт, нэгжээс, нийт хураан авсан ургацаараа, трактораар гүйцэтгэсэн бодит болон жишмэл га, комбайнаар шууд хураалтаар явсан га талбайн ажлын үзүүлэлтээр тэргүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг шалгаруулан улсын аваргад нэр дэвшүүлэн ХХААХҮЯаманд хүргүүлээ. Үүнд:

УЛСЫН АВАРГА ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН:

- Аргалант сум: Хос бэрс ХХК
- Жаргалант сум: Хонгор буудай ХХК
- Эрдэнэсант сум: Дөлгөөн батхаан ХХК

УЛСЫН АВАРГА МЕХАНИКЖУУЛАГЧ:

- Баянцогт сум: Түмэн-Атар ХХК-ний Механикжуулагч Б.Баясгалан

- Жаргалант сум: Алтан залаа ХХК-ний Механикжуулагч Г.Баатархүү
- Цээл сум: Цээлийн хур ХХК-ний Механикжуулагч Д.Ганбаатар

УЛСЫН АВАРГА ТАРИАЛАНЧ:

- Угтаалцайдам сумын тариаланч Л.Лхагвасүрэн
- Эрдэнэ сумын тариаланч З.Лодой нарыг тус тус шагнуулахаар уламжилсан.

Мал аж ахуйн хүрээнд: Засгийн газрын 2023 оны 08 дугаар тогтоолын дагуу “Улсын аварга малчин”, “Улсын хошой аварга малчин”, “Улсын аварга фермер”, “Улсын аварга саальчин” шагналд нэр дэвшигчдийн материал, шалгуур хангасан малчдын мэдээллийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ХХААХҮЯ-руу хүргүүллээ.

- Улсын хошой аварга малчин-2
- Улсын аварга малчин-10
- Улсын аварга фермер-2
- Улсын аварга саальчин-1 тус тус нэр дэвшүүлэн

Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн “Таван эрдэнэ” нэвтрүүлгийн нэрэмжит “Алтан төлийн эзэн” шагналд 8 сумын 10 малчин нэр дэвшүүлэн холбогдох мат материалыг уламжлав.

Аймгийн Онцгой комиссын 2023 оны 01 дүгээр хурлын шийдвэрээр өвөлжилт хүндэрсэн Сүмбэр, Жаргалант, Борнуур, Баянчандмань, Батсүмбэр сумдад ажиллаж, цагийн байдалд үнэлэлт өгч, малчин өрхийн өвөлжилттэй танилцаж ажилласан.

Том малын зүй бус хорогдлын мэдээг долоо хоног бүрийн Лхагва гарагт сумдаас авч нэгтгэн ХХААХҮЯ-ны МААХБЗГ-ын мэргэжилтэнд хүргүүлэн ажиллаж байна. Одоогоор аймгийн хэмжээнд нийт 5775 толгой мал хорогдсон мэдээтэй байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/22 “Өвс, тэжээл олгох тухай” захирамжаар өвөлжилт хүндэрсэн 17 суманд 5000 боодол өвснийг үндсэн үнэ 9740 төгрөгөөр, 27 суманд улсын аюулгүйн нөөцөөс 181.4 тн хорголжин тэжээлийг 50 хувийн хөнгөлөлттэй 13600 төгрөгөөр олгож байна.

Мал аж ахуйн нэгдсэн мэдээллийн санд “2022 онд тоологдсон малчин өрхийг бүртгэлд хэрхэн нэмэх тухай” сургалтыг 27 сумын мэргэжилтнүүдэд цахимаар зохион байгууллаа.

Мал эмнэлгийн үйлчилгээний хүрээнд: Баян сумын Өгөөмөр багийн Хоолойн гашуун гэх газарт бог малын мялзан өвчин оношлогдож хорио цээрийн дэглэм тогтоосон. Өвчилсөн 375 бог малаас 187 бог үхэж, устгасан, 188 шинж тэмдэг бүрэн арилж, голомтын болон устгалын цэгийн 2200м² талбайд халдваргүйтгэл хийгээд байна.

2023 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр баянчандмань сумын Эрдэнэ багийн Эхэн шорной гэх газарт хонины цэцэг өвчин оношлогдож хорио цээрийн дэглэм тогтоосон. Өвчилсөн 96 хониноос 5 хонь устгаж, 89 хонины шинж тэмдэг бүрэн арилж, голомтын болон устгалын цэгийн 4850м² талбайд халдваргүйтгэл хийж, голомт болон сэжигтэй бүсийн 9 өрхийн 8400 хонийг цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамруулсан.

Гоц халдварт бог малын мялзан, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх мэдээллийг цахим мэдээллийн хэрэгслээр 6400 малчин, мал бүхий иргэдэд хүргээд байна.

Энэ оны 01 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд Аргалант, Архуст, Баян, Баяндэлгэр, Батсүмбэр, Баянжаргалан, Баянцогт, Баянчандмань, Лүн, Мөнгөнмөрөт, Заамар, Зуунмод, Сүмбэр сумдад Адуу-205 Үхэр-206 Хонь-3325 Ямаа-1968 нийт 6088 мал зүй бусаар хорогдсон байна.

Тайлант хугацаанд амьтан хэрэгцээлэх-301, бүтээгдэхүүн-1915, отор нүүдэл-197, үржил-144 нийт 2557 мал эмнэлгийн гэрчилгээг олгож, 50 дуудлагын дагуу 102 малд үйлчилгээ үзүүлээ.

Лүн суман дахь Мал эмнэлгийн хяналтын цэг 4 ээлжээр 24 цагт малын шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэн явж байгаа нийт 135 тээврийн хэрэгсэл, адуу 220, үхэр 5, хонь 148, ямаа 14 нийт 387 толгой амьд мал, 158021 кг мах, 19789 ширхэг арьс шир, 920 кг ноодлуур, 400 кг дайвар бүтээгдэхүүнд эрүүл ахуйн үзлэг хийн мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт шалгалт хийж ажилласан..

Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хүрээнд: Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрийн газраас зохион байгуулж буй “Амар байна уу” үзэсгэлэн худалдаанд Угтаалцайдам, Алтанбулаг, Зуунмод сумын 5 жижиг дунд үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж оролцож 58.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлууллаа. Мөн сар шинийн баярыг угтаж 02 дугаар сарын 10-12 ны өдрүүдэд Зуунмод суманд зохин байгуулагдаж “Төв нутгийн 100 жил-Цагаан сар 2023” үзэсгэлэнгийн бэлтгэлийг ханган ажиллалаа.

Төрийн аудитын газарт Хоршоо хөгжүүлэх сангийн 2022 оны жилийн эцсийн тайланг хүргүүллээ.

СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:

Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт, стандартын мэдээлэл лавлагааны хүрээнд: Тохирлын үнэлгээнд хамрагдах хүсэлт ирүүлсэн Зуунмод, Сэргэлэн сумдын 11 аж ахуйн нэгж, иргэний бүтээгдэхүүн үйлчилгээг холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээнд хамрууллаа.

Хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын хүрээнд: Массын хэмжлийн төрлөөр Зуунмод, Сэргэлэн сумын худалдаа үйлчилгээ, нийтийн хоол үйлдвэрлэлийн 43 ш массын хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажууллаа.

Итгэмжлэгдсэн лабораторийн хүрээнд: Махан бүтээгдэхүүн, гүний ус, хоол, хүнсний ногоо, хэрчсэн гурил, аарц, гурилан 8 бүтээгдэхүүний 36 сорьцод 117 үзүүлэлтээр эрүүл ахуйн хими, нян судлалын шинжилгээ хийж ажиллалаа.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Ойн бодлогын хүрээнд: Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Хан Хэнтийн Дархан Цаазат газарт хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арга хэмжээ авч ажиллалаа. Үүнд:

- Хяналт шалгалтын явцад 5 тээврийн хэрэгсэл 27 иргэнийг шалгахад 2 иргэн хууль бусаар 1 толгой Ахууна шувуу агнасан, мөн 4 ширхэг галт зэвсэг, 1 ширхэг чонын хавх авч явсан тул Экологийн цагдаа хураан авч тэмдэглэл үйлдсэн.

- Хан Хэнтийн Дархан Цаазат Газрын Хамгаалалтын Захиргаантай 1000м³ Шинэс мод бэлтгэх гэрээ байгуулсан “ЭБЭЭ” ХХК нь 12 тэвш буюу 150 метр куб Хуш мод бэлтгэсэн зөрчил гаргасан тул харьяаллын дагуу аймгийн Экологийн цагдаагийн албанд шилжүүлээ.

Биологийн төрөл зүйл: Өвөлжилт хүндэрсэн Бүрэн, Эрдэнэсант, суманд 40 боодол өвс, ногоон тэжээл, 20 шуудай хужир тавьж зэрлэг амьтдын идэш тэжээлийг хомсдолоос сэргийлэх биотехникийн арга хэмжээ авлаа. Биотехникийн арга хэмжээнд нийт 800.0 мянган төгрөг зарцуулсан.

Аялал жуулчлалын чиглэлээр: Уул ус байгаль дэлхийдээ хүндэтгэл үзүүлж шинэ оны анхны нарнаас энерги авахын зэрэгцээ дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, нийтийн биеийн тамирыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 6 дахь жилдээ 1сарын 1нд “Шинэ оны анхны нар харах” аяллыг зохион байгууллаа. Аялалд нийт 40-50 хүн хамрагдлаа.

УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

Урьдчилан мэдээлэх: Нарийвчилсан мэдээ, 1 хоногийн мэдээ, 5 ба 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7,10 хоног тутмын цаг агаарын тойм, энэ сарын нарийвчилсан анхааруулах мэдээ 11,24,25-ний өдөр 3 удаа, хоногийн анхааруулах мэдээ 10, 11,21,23,24,25,-ний өдрүүдэд 6 удаа, цас орж, зарим газраар цасан шуурга шуурч, салхи шуургатай байхыг анхааруулсан. Нарийвчилсан сэрэмжлүүлэг мэдээ өгөөгүй, хоногийн сэрэмжлүүлэг мэдээг 24-ний өдөр 1 удаа их цасны сэрэмжлүүлэг мэдээг гаргаж И-мэйл-ээр дамжуулж, www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, TuvTsaguur page-д байршуулан, өдөр тутмын цаг агаарын мэдээг Зуунмод сумын ОНИМ-ийн ажилтанд И-мэйл ба “Дотоод удирдлагын систем”-ээр явуулах ажил тасралтгүй хийгдэж, байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр байршуулан ард иргэдэд үйлчилж байна.

Байгаль орчны шинжилгээний лаборатори: Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойлж байна. Агаарын чанарын ажиглалтыг 01 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар нийт 51 удаа ажиглалт хийсэн ба хүхэрлэг хийн багаж эвдэрсэн тул хэмжилт хийгдэхгүй байгаа азотын давхар ислийн дундаж агууламж 0.020 мг/м³ үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад азотын давхар ислийн дундаж агууламж 0.003мг/м³-ээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Гадаргын усны чанар: Усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 01 дүгээр сард Туул-Лүн, голын хяналт шинжилгээг хийхэд цахилгаан дамжуулах чанар нь Туул-Лүн 591 uS/cm, гарлаа.

Ус судлалын салбар: Төв аймгийн нутаг дэвсгэрт 7-н ус судлалын харуул ажиллаж байгаагаас 2023 оны 01 дүгээр сарын 21-ний байдлаар усны түвшин: Хэрлэн гол Хэрлэн-Хонгон 207 см, Хэрлэн-Мөнгөнморьт 104 см, Туул гол Туул-Алтанбулаг харуулд 553 см, Туул-Лүн харуулд 128 см, Туул-Заамар харуулд-155 см тус тус байсан ба өмнөх оныхтой харьцуулахад усны түвшин Хэрлэн голын дагуух Хэрлэн-Хонгон харуул 13 см их, Хэрлэн-Мөнгөнморьт харуул 18 см бага, Туул голын дагуух Туул- Алтанбулаг харуул, Туул-Лүн харуул, Туул-Заамар харуулууд 8-19 см бага, Сөгнөгөр голын дагуух Сөгнөгөр-Сөгнөгөр харуул, Шивэрт голын дагуух Шивэрт-Борнуур харуулууд ёроолдож хөлдсөн. Голуудын мөсний зузаан 61-104 см харилцан адилгүй байна.

ДОЛОО. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ХҮРЭЭНД:

1. Аймгийн “Эрдэмтдийн зөвлөл”-тэй хамтран төрөлх нутгийнхаа 100 жилийн ойд зориулан "Монгол төрийн голомт" эрдэм шинжилгээний хурал, аймгийн эрдэмтдийн чуулганыг "Шинэ

зууны хөгжлийг Шинжлэх ухаанаар түүчээлнэ" уриан дор зохион байгууллаа. Чуулганд Төв аймгаар овоглосон 5 академич, 220 гаруй доктор, профессорууд, залуу судлаачид оролцлоо. Төв аймаг аливаа бодлого шийдвэрээ гаргахдаа судалгаа шинжилгээнд үндэслэн, шинжлэх ухаанч гарц шийдлийг эрэлхийлэн, нийлүүлэгч аймгаас үйлдвэрлэгч аймаг болох зорилт дэвшүүлж, Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлт, соёлын болон аялал жуулчлалын стратеги төлөвлөлтүүдээ эрдэмтдийн баг судлаачидтайгаа хамтран хэрэгжүүлж, ажиллахаар боллоо.

2. “Зоонозын өвчнөөс нийтийн эрүүл мэндийг хамгаалах хамтарсан салбар зөвлөл”-ийг аймгийн Засаг даргын 2023 оны А/11 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулж, салбар зөвлөлийн ажиллах журмыг баталж, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, үйл ажиллагааг тогтмолжуулах чиглэл өглөө.
3. Аймгийн ЭМГ-тай хамтран анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг хэлэлцүүлэн, 2023 оны төлөвлөлтийн талаар зөвлөмж, чиглэл өгөх цахим хэлэлцүүлэг зохион байгууллаа.
Хэлэлцүүлэгт аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Нэгдсэн эмнэлгийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүд, 27 сумын Засаг дарга, сумын ЗДТГ-ын Нийгмийн бодлогын мэргэжилтнүүд нийт 150 гаруй албан хаагчид оролцлоо.
4. Жендэрийн салбар хороог хуралдуулж, 2023 оны төлөвлөгөөг боловсруулан, шаардлагатай төсвийг баталлаа.
5. Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэх бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, илтгэл мэдээлэл, танилцуулгыг боловсруулан, тайлагналаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД:

Эмнэлгийн тусламж үйлчилгээ:

1. Аймгийн хэмжээнд 2022 оны жилийн эцсийн статистик үзүүлэлтээр 791 эх төрж өмнөх оны мөн үеэс 339 тохиолдлоор төрөлт буурч, 800 нярай бүртгэгдсэн. Жирэмсний хяналтад шинээр нийт 1287 эх, үүнээс эхний 3 сартайд 92.85%-ийг хяналтад хамрууллаа. Эрүүл мэндийн байгууллагууд нийт 340139 хүнд үзлэг хийж, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 34.6%, амбулаторын үзлэг 53.5%, идэвхтэй хяналт 8.2% байна. Түргэн тусламжийн дуудлагаар 16747 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж үүнээс алсын дуудлага 24.6%, осол гэмтлийн дуудлага 2.78%-ийг эзэлж байна. Эмнэлэгт 16976 хүн эмчлэгдэн нийт 124996 ор хоног ашиглан, дундаж ор хоног 7.4 байна. Аймгийн хэмжээнд нийт 519 нас баралт, үүнээс эмнэлгийн нас баралт 21,19%, гадны шалтгаант нас баралт 117 буюу 22,54%-ийг эзэлж байна.
2. Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн шинэ барилга ашиглалтад орж нээлт хийсэн. Тус ЭМТөвд Улсын төсвийн 20.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4 төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэн, тусламж үйлчилгээний чадавх сайжирлаа.
3. Аймгийн хэмжээнд отор нүүдлээр аймаг дотроо 148, өөр сум аймгаас ирсэн 292, өөр сум аймагт 237 хүн отроор өвөлжиж байна. Үүнд жирэмсэн эх 5, 0-5 насны хүүхэд 78, өндөр настан 34, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 4 нийт 121 эрсдэлт бүлгийн иргэд, хяналтад байна.
4. Зуунмод суманд угаартсан 6 хүнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж, мэдээллийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргүүлээ.

Халдварын хяналт, сэргийлэлт:

5. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын 5 тохиолдол бүртгэгдэн, эмчлэгдлээ. Аймаг ковид-19-ын тархалтын үнэлгээгээр ногоон түвшинд, амбулаторын үзлэгийн 9,46%-ийг томуу, томуу төст өвчин эзэлж, хүндрэлийн үнэлгээгээр алаг цоог дэгдэлтийн буюу улбар шар түвшинд байна.
6. Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн 4 төрлийн 14 халдварт өвчний тохиолдолд хариу арга хэмжээ авч тандалт, судалгаа хийж, ажиллалаа.
7. 2023 онд төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн болон төрөлжсөн мэргэшлийн, мэргэшил дээшлүүлэх сургалтад төрийн сангийн тэтгэлгээр 48 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах захиалгыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн. Аймгийн Эрүүл мэндийн салбарт 101 сул ажлын байр бүртгэгдэн, хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх чиглэлээр салбар дундын оролцоог ханган ажиллаж байна.
8. ЭМГ-ын Орчны эрүүл мэндийн лабораторид аймгийн хэмжээнд унд ахуйн ус, агаар, арчдас нийт 338 сорьцод 687 үзүүлэлтээр шинжилгээ хийж, дүгнэлтийг хүргүүлээ.

Сургалт, бусад арга хэмжээ:

9. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах танхимын болон цахим, ажлын байрны дадлагажуулах сургалт нийт 6 удаа зохион байгуулан, 251 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан, чадавхжууллаа.
10. ЭМГ, ХХААГ-тай хамтран Баянчандмань, Борнуур, Батсүмбэр, Жаргалант, Сүмбэр сумдын өвөлжилтийн бэлэн байдалд үнэлгээ хийж, заавар, зөвлөмж өглөө.

11. Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан, санхүү, тоног төхөөрөмж, нөөц, хүчин чадлын тулгалт хийж, Hinfostata программд шивж нэгтгэсэн. Аймгийн хэмжээнд 1300 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажиллаж байна.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ХҮРЭЭНД:

1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/110 дугаар тушаалаар “Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн боловсролын чанарыг сайжруулах” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймаг, нийслэл, дүүргийн тэгш хамруулах боловсролын асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал”, “Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн боловсрол” сургалтад 7 цэцэрлэгийн 13 багш, 2 ЕБС-ийн 42 багш цахимаар хамрагдсан.
2. Аймгийн Засаг дарга Глобаль Удирдагч Их сургуультай хамтран ажиллах гэрээний дагуу 5 сумын ЕБС-ийн гадаад хэлний 12 багш түвшин ахиулах сургалтад амжилттай хамрагдлаа.
3. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2023 оны А/01 дүгээр тушаалаар 2023 оныг сургалтын байгууллагын менежментийг сайжруулах жил болгон зарлаж, аймгуудын Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн дүүргүүдийн Боловсролын хэлтсийн мэргэжилтнүүд "Сургуулийн менежментийг сайжруулах аргачлал" сэдвээр зохион байгуулагдсан сургалт, семинарт аймгийн БШУГ-ын 5 мэргэжилтэн хамрагдлаа. Боловсролын байгууллагын болон багшийн үнэлгээний үр дүнгийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлон, аймгийн хэмжээнд ЕБС, СӨБ-ын удирдлагуудыг чадавхжуулах сургалт зохион байгуулахаар төлөвлөөд байна.

АЛБАН БУС НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭНД:

1. “ӨВ СОЁЛОО ЭРХЭМЛЭЖ ҮНДЭСНИЙ БИЧГЭЭ СУРЦГААЯ- 2025” аяны хүрээнд Монгол хэл бичгийн сургалтыг нийт 13 байгууллагын 271 албан хаагчдад зохион байгууллаа.
2. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, “И-Монгол Академи” БЕГ-ын НТБХэлтсээс аймгийн Насан туршийн боловсролын төв, сумдын нэгжийн багш нартай хамтран “Иргэдийн цахим ур чадварын хэрэгцээ тодорхойлох түүвэр судалгаа” авч, нийт 465 иргэдийг хамрууллаа.
3. Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан Насан туршийн боловсролын төв болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарын сурах, хөгжих хэрэгцээг тодорхойлох судалгаанд аймгийн Насан туршийн боловсролын төв, сумдын нэгжийн нийт 31 багш хамрагдлаа.

СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД:

1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газартай хамтран аймгийн соёл, урлагийн 30 байгууллагуудын удирдлагуудад 2022 оны жилийн эцсийн статистик мэдээнд тулгуурлан мэргэжил арга зүйн чадавхжуулах сургалтыг 01 дүгээр сарын 05, 06-ны өдрүүдэд зохион байгууллаа.
2. Аймгийн Нийтийн номын сан нь нийтийн уншлагын танхимаар 204 байнгын уншигч, 837 ирэгсэд, нийт 2154 ном олгон уншуулж үйлчилсэн байна. “Цахим мэдээллийн танхим”-аас уншигч хүүхэд залуучууд, иргэдэд зориулан Цахим сан хөмрөгийн сурагчдын заавал унших ном, үлгэр болон мэдээ мэдээллийг Нийтийн номын сангийн <https://library.to.gov.mn> цахим хуудсанд байршууллаа.
3. Аймгийн Музей соёлын өв, үнэт зүйлийг бүртгэн баримтжуулах, хадгалж хамгаалах, нийтийн хүртээл болгох зорилгоор “Төв аймгийн Музей” пэйж хуудсыг ажиллуулан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл”, “Соёлын биет өв” түүний талаарх мэдээллийг олон нийтэд хүргэн соёлын өвийн ойлголтыг нийтэд сурталчилан таниулж байна.

ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД:

Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

1. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2023 оны анхдугаар хуралдааныг зохион байгуулж, 2023 оны төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа.
2. Аймгийн аварга шалгаруулах “Цодгор хүү-2023” тэмцээнийг “Төв аймгийн Шатарын холбоо” ТББ-тай хамтран Зуунмод суманд зохион байгууллаа. Тэмцээнийг 5, 7, 9, 11 насны ангиллаар зохион байгуулж, 16 сумын 235 шатарчин оролцож, аваргаа шалгарууллаа. Улсын аварга шалгаруулах “Цодгор хүү-2023” тэмцээнд 8 хүүхэд оролцох эрхээ авлаа.

Гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

3. Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран албадлагын арга хэмжээ авагдсан 11 иргэнийг “Гэр бүлийн сэтгэл зүйг төлөвшүүлэх нь” сэдэвт сургалтад хамрууллаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

1. ЭМД-ын гэрээ бүхий 80 Эрүүл мэндийн байгууллагын гэрээний хэрэгжилтийг үнэлэн, хангалтгүй үнэлгээтэй 5 эмийн санд зөрчлийг арилгах чиглэлээр албан шаардлага хүргүүлсэн.
2. ЭМДаатгалын хэлтсээс Эрдэнэсант, Цээл, Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвд зөвлөн тусалж ажиллан, ЭМД-ын тухай хууль, ЭМДҮЗ-ийн тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулан чадавхжууллаа.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Хяналт шалгалтын чиглэлээр:

1. Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн 15 өргөдөл, гомдол, 19 албан бичгийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өглөө. Өргөдөл, албан бичгийн 8 ААН, байгууллагад НДШимтгэл дутуу тооцсон зөрчилд 0.9 сая төгрөгийн Улсын байцаагчийн акт тогтоож 100 хувь барагдууллаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын чиглэлээр:

2. Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын хурлыг 4 удаа 30 цаг хуралдаж, нийт 190 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 22 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 152 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 16 иргэнийг цуцалсан байна.

Нийгмийн даатгалын сангийн чиглэлээр:

3. Хамтран ажиллах гэрээний дагуу Хаан, Төрийн банкаар 17744 тэтгэвэр авагчдад 8,4 тэрбум төгрөгийн тэтгэврийг олголоо.

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Нийгмийн халамжийн чиглэлээр:

1. 2023 оны 1-р сарын байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэр 1856 иргэнд 522,6 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмж 1136 иргэнд 100,8 сая төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тусламж 272 иргэнд 66,8 сая төгрөг, ахмад настны хөнгөлөлт тусламжид 67 ахмад настанд 9,9 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжид 98 иргэнд 10,2 сая төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 2337 иргэнд 27,7 сая төгрөг, жирэмсэн 642 эхэд 23,8 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 3777 иргэнд 23,8 сая төгрөгийн тэтгэмж, ихэр хүүхэд төрүүлсэн 1 иргэнд 2,0 сая төгрөг, Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 32864 хүүхдэд 3286,4 сая төгрөг тус тус олголоо.

2. Шинээр төрсөн 109 хүүхдийн мэдээллийг и-халамж системээр бүртгэж, Хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой журам, чиглэлийн талаар 700 гаруй иргэнд мэдээлэл өглөө.

3. Нийгмийн хөгжлийн чиглэлээр: “Төгсөлтийн аргачлал” төсөл хөтөлбөрт 2023-2024 онд шинээр сонгох 457 өрхийн квотыг гаргаж, сонгогдох өрхийн шалгуур, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, эрчимжүүлэх ажлын чиглэлийг сумдын Засаг дарга, хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт хүргүүллээ.

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 2 удаа хуралдаж, шинээр 4 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоож, 2 хүүхдийг цэцэрлэг, сургуульд хамруулах шийдвэр гаргалаа.

5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 471 өрхийн 2337 иргэнд 27,7 сая төгрөгийн 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн олгож хүнс тэжээлийн дутагдлаас урьдчилсан сэргийлж ажиллалаа.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

1. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн ejob платформд 1-р сарын байдлаар 30 ажил олгогч, 204 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 15 ажил олгогчийн 39 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг хүлээн авч 6 иргэн ажилд зуучлагдлаа.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан: Тайлант хугацаанд 186 иргэний 50261,05 мянган төгрөгийн эргэн төлөлтийг ХЭДСанд төвлөрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн ажлын байрны төлбөрт 19740,0 мянган төгрөг ХЭДСанд төвлөрүүлсэн байна.

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийн журам, банкнаас тавьж буй шаардлага, төслийн шалгаруулалтын талаарх мэдээллийг иргэдэд хүргэлээ. Жижиг зээлийн арга хэмжээнд оролцохыг хүссэн иргэдийг бүртгэж, Зээлийн өмнөх сургалтыг “Төсөл боловсруулах” чиглэлээр цахим болон танхимаар нийт 50 гаруй иргэдийг хамруулан зохион байгууллаа.

Бусад чиглэлээр

1. Хөшгийн хөндийн Шинэ Улаанбаатар олон улсын нисэх онгоцны буудлын цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан ажиллах Аппола бьюлдинг сервис ХХК-ийн захиалгын дагуу цэвэрлэгээний ажлын байранд ажиллах хүсэлтэй 17 иргэнийг бүртгэн, 12 иргэн анхан шатны ярилцлагад тэнцлээ.

2. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нээлттэй төвийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ААНБ-уудтай “Өглөөний уулзалт”-ыг зохион байгуулж, 2023 оны төлөвлөгөөг боловсруулан батлууллаа. Тус төвөөр дамжуулан 34 хүртэлх насны залуучуудыг хөдөлмөрт бэлтгэж, ажлын байранд зуучлах бөгөөд ахмад багш нар залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн үнэ цэнэ, иргэн өөрийгөө таньж мэдэх талаас нь зөвлөх үйлчилгээ үзүүлж хамтран ажиллахаар шийдвэрлэлээ.

3. Киока олон улсын байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, Нийгмийн халамжийн чиглэлээр харилцан туршлага судлах 1 мэргэжилтэн урьж, жилийн хугацаанд ажиллах гэрээ байгууллаа.

БИЕИЙН ТАМИР СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

1. Л.Энхбаяр дасгалжуулагчтай Чөлөөт бөхийн өсвөрийн шигшээ багийн тамирчид ОХУ-ын Красноярск, Улаан-Үдэ, Якут улсын шигшээ багийн тамирчидтай хамтарсан бэлтгэл хийж 18 тамирчин амжилттай оролцлоо.
2. Аймгийн хүүхдийн спортын VII их наадмын аварга шалгаруулах тэмцээнийг цана, тэшүүрийн төрлөөр зохион явуулж 62 тамирчин оролцож, улсын аварга шалгаруулах тэмцээнд цана, тэшүүр, жү-до, жюү-жицү бөх, пауэрлифтингийн төрлүүдээр оролцон 11 алт, 39 мөнгө, 26 хүрэл нийт 63 медаль хүртлээ.
3. Мөнгөн өвөл цасны баярыг 12 сум, 8 албан байгууллага, аж ахуйн нэгж албан хаагчдынхаа дунд зохион байгуулж 2885 хүнийг идэвхтэй хөдөлгөөнд хамрууллаа.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР